



2024 оны үйл ажиллагааны тайлан



Агуулга

ТУЗ-ийн даргын мэндчилгээ	01
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	02
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд	03
ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тойм	06
Компанийн засаглал	10
Компанийн бүтэц, зохион байгуулалт	11
Санхүүгийн гүйцэтгэл	12
Макро эдийн засаг - 2024	13
Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл	18
Хүний нөөцийн бодлого, сургалт хөгжил, соёлын арга хэмжээ	19
Компанийн онцлох үйл явдлууд	22
Дижитал шилжилт	23
Дотоод хяналтын тогтолцоо	26
Эрсдэлийн удирдлага	27
Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг	30



ТУЗ-ийн даргын мэндчилгээ

С. Жавзандулам /ТУЗ-ийн дарга/

Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК-ийн нийт харилцагчид, түншүүд та бүхэндээ 2024 оны жилийн тайлангаа танилцуулж буйдаа таатай байна.

2024 онд ТУЗ-ийн стратегийн түвшний шийдвэр, бодлого нь гүйцэтгэх багийн хэрэгжилттэй уялдан, байгууллагын засаглалын соёлыг төлөвшүүлж чадсанаар СЗХ-ны Компанийн засаглалын кодексийн үнэлгээнд 97.2%-ийн амжилт үзүүлсэн нь манай байгууллагын засаглалын төлөвшил, хариуцлагын баталгаа боллоо.

Цаашид бид компанийн гадаад эх үүсвэрийг төрөлжүүлэх, IPO-ийн бэлтгэлийг хангах, хиймэл оюун ухаанд суурилсан экосистемийг бий болгох зэргээр урт хугацааны хөгжлийн бодлогыг дэмжин, тогтвортой, ил тод засаглалаа улам бэхжүүлэн, хадгалж ажиллахын төлөө ажиллах болно.

Байгууллагын амжилт бүрийн ард зогсож буй ажилтнуудын тууштай хөдөлмөр, хөрөнгө оруулагчдын үнэнч итгэл, харилцагч, түншүүд, ТУЗ-ийн гишүүд та бүхэндээ амжилт хүсэж, талархал илэрхийлье

Хүндэтгэсэн,

С. Жавзандулам Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга



Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Б. Хуншагай /Гүйцэтгэх захирал/

2024 онд “Нэткапитал финанс корпораци ББСБ” ХХК “Дижитал шилжилтээр манлайлна” хэмээх эрхэм зорилгоо улам тодруулан, хиймэл оюун ухаанд суурилсан шийдлүүдээ зах зээлд бүрэн уялдуулж, харилцагч төвтэй экосистем-ийг харилцагчийн насан туршийн үнэ цэнийг тодорхойлох CLV модель, эрсдэлд суурилсан скоринг, барьцаа хөрөнгийн үнэлгээний автомат систем зэрэг дата төвтэй инновациудыг бизнесийн шийдвэр гаргалтад үр дүнтэй ашиглаж эхлэв.

2024 онд бидний ололт амжилт зөвхөн дотоод шинэчлэлээр хязгаарлагдсангүй. Парисын Зуны Олимп, Паралимп болон Евро 2024 хөл бөмбөгийн тэмцээний шууд дамжуулалтын ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллаж, Монгол улсынхаа баг тамирчдад санхүүгийн болон бусад дэмжлэгийг үзүүлж тамирчдынхаа амжилтыг олон нийтэд түгээхэд идэвхтэй оролцсон нь компани хэрэглэгчидтэйгээ зөвхөн санхүүгийн үйлчилгээний хүрээнд бус соёл, спорт, нийгмийн үнэт зүйлсээр дамжуулан холбогдох боломжийг бүрдүүлсэн том алхам байлаа.

2025 он бол бидний хувьд олон улсын зах зээлд гаргах IPO-ийн бэлтгэлээ үргэлжлүүлэн хангах, хиймэл оюун ухаанд суурилсан экосистемээ бүрэн хэрэгжүүлэх, инновац дээр суурилсан өсөлтийг хурдасгах стратегийн шийдвэрийн он байх болно. Хөгжил дэвшлийн маань суурь болсон хамт олныхоо хичээл зүтгэл, хөрөнгө оруулагчдын итгэл, түншүүдийн дэмжлэгт талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,

Б.Хуншагай “Нэткапитал финанс корпораци ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн



С.Жавзандулам /ТУЗ-ийн дарга/

Нэткапитал финанс корпораци ББСБ ХХК-ийн эцсийн өмчлөгч бөгөөд 2024 оноос хойш компанийн ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байна.

Ажлын туршлага:

- 2024 - Одоо ТУЗ-ийн дарга
- 2022 - 2024 Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч, Нэткапитал финанс корпораци ББСБ ХХК
- 2021 - 2022 Бизнес хөгжлийн менежер, Нэткапитал финанс корпораци ББСБ ХХК
- 2019 - 2021 Үйл ажиллагааны менежер, Нэткапитал финанс корпораци ББСБ ХХК

ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүн



Л.Болорчимэг
/ТУЗ-ийн хараат бус гишүүн/

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2021 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ажлын туршлага:

- 2019-одоо: Гүйцэтгэх захирал, Үүсгэн байгуулагч, Ворд медиа ХХК,Өрөг.мн
- 2012-2019: Сэтгүүлч, Шинэ дэлхий, MNC, NT телевиз



А.Урангоо
/ТУЗ-ийн хараат бус гишүүн/

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2020 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ажлын туршлага:

- 2013-Одоо: CEO, Үүсгэн байгуулагч, UA Consulting, Properties, Investment



Ш.Чуданжий
/ТУЗ-ийн хараат бус гишүүн/

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2020 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ажлын туршлага:

- 2017- Одоо: Захирал, СПЕК ХХК
- 1999-2009: CEO, Зоос банк
- 1993-1999: Эдийн засагч, МХАА-н банк

ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүн



С.Оргодол
/ТУЗ-ийн хараат бус гишүүн/

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2024 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ажлын туршлага:

- 2020-2024 Эрсдэл хариуцсан захирал, Богд банк
- 2009-2020: Гүйцэтгэх захирлын орлогч, Худалдаа Хөгжлийн Банк
- 2008-2009: ТУЗ-ийн дарга, Монгол Шуудан Банк



Б.Мөнхжаваа
/ТУЗ-ийн хараат бус гишүүн/

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2022 оны 12 сараас компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна

Ажлын туршлага:

- 2021-2022: Захирал, “Growth source” ХХК
- 2007-2020: Хүний нөөцийн газрын захирал, Худалдаа Хөгжлийн банк



Л.Оргил
/ТУЗ-ийн хараат бус гишүүн/

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2022 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ажлын туршлага:

- 2020-одоо: Гүйцэтгэх захирал, Хаан даатгал ХХК
- 2019-2020: Санхүү эрхэлсэн захирал, Хаан даатгал ХХК
- 2014-2019: Борлуулалт, сувгийн удирдлагын хэлтэс, Иргэдийн даатгалын хэлтэс захирал, Хаан Даатгал ХХК
- 2011-2014: Эдийн засагч, Эрэл ХХК

ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тойм

ТУЗ-ийн хурал

Хурлын тоо - 10
Шийдвэрийн тоо - 13

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Хурлын тоо - 5
Дүгнэлтийн тоо - 5

Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны Засаглалын кодекст нийцүүлж, дараах шийдвэрүүдийг гарган ажиллав.

1. Компанийн 2023 оны төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл, Компанийн 2024 оны төсөв батлах тухай
2. Дотоод аудитын 2023 оны тайлан, 2024 оны төлөвлөгөөг батлах тухай
3. Засаглалын кодексын тайлан, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг үйл ажиллагааны журам шинэчлэн батлах тухай, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг гишүүд шинэчлэн батлах тухай
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан дуудуулах тухай
5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай
6. Компанийн үнэт зүйлийг шинэчлэн батлах тухай
7. Компанийн бүтэц, зохион байгуулалт шинэчлэн батлах тухай

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо


Компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг хэлэлцэж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний шийдвэр гаргах, тулгарсан асуудлыг шийдвэрлэх, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангах.



Дарга: С. Оргодол



Гишүүн: А. Урангоо



Гишүүн: С. Жавзандулам

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, Цалин урамшуулал, засаглалын хороо

Компанийн ТУЗ-ийн гишүүд, компанийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллыг талаар баримтлах бодлогыг баталж, хянан.

ТУЗ-ийн гишүүн болон компанийн эрх бүхий албан тушаалтанд тавигдах шаардлага, гишүүдийг сонгон шалгаруулах журам боловсруулах, ТУЗ-ийн гишүүн, түүнчлэн хараат бус гишүүнд нэр дэвшигчид нь тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэн шалгаж, дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах болон томилогдон ажиллаж байгаа ТУЗ-ийн гишүүд нь шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллахад анхаарах

Жил бүр стратеги болон бизнес төлөвлөгөөний түлхүүр үзүүлэлтээс хамаарч гүйцэтгэх удирдлагын багийн цалин урамшууллыг тухайн жилийн 1-р улиралд багтаан ТУЗ-аар батлуулдаг.



Дарга: Б. Мөнхжавхаа



Гишүүн: Б. Болорчимэг




Гишүүн: С. Жавзандулам

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо


Хараат бус ба бодит байдлыг хангах, аудитын нөөц, аудитын хамрах хүрээний хязгаарлалт, аудитын жилийн төлөвлөгөөг батлах, аудитын тайлагналын процесс, ерөнхий аудиторыг томилох, чөлөөлөх, дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.



Дарга: Л. Оргил



Гишүүн: Ш. Чуданжий





Гишүүн: С. Жавзандулам

Компанийн засаглал

Нэткапитал финанс копораци ББСБ ХХК нь Монгол улсад бүртгэлтэй, хязгаарлагдмал хариуцлагатай хэлбэрээр байгуулагдсан ББСБ бөгөөд Монгол улсын хууль тогтоомжоос гадна банкнаас бусад зохицуулалттай салбарын зохицуулагч Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-оос баталсан Компанийн засаглалын кодексийг дагаж мөрдөх үүрэгтэй.


Компанийн урт хугацааны тогтвортой хөгжилд хүрэхийн тулд бид хувь нийлүүлэгчид, харилцагчид, ажилтнууд болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалж, тэдэнтэй итгэлцэлд суурилсан хамтын ажиллагааг хөгжүүлэхийг зорьдог.

СЗХ-ны 2024 оны “Компанийн засаглалын кодексийн зайны үнэлгээ”-гээр Нэткапитал финанс корпораци ББСБ ХХК нь 97.2%-ийн үнэлгээгээр 2-р байранд орсон.




2024 оны санхүүгийн гүйцэтгэл


Нийт хөрөнгө:
269 тэрбум төгрөг
+104%




Зээлийн багц:
228 тэрбум төгрөг
+102%



Эх үүсвэр:
155 тэрбум төгрөг
+124%



Цэвэр ашиг:
14.1 тэрбум төгрөг **+69%**



Ашигт ажиллагаа:

 **ROA: 7%**

 **ROE: 29%**

Макро эдийн засаг – 2024 Нөлөөлөл

ГАДААД ОРЧИН

БНХАУ болон АНУ-ын худалдааны дайны нөлөөгөөр БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарах хүлээлттэй байна.

Гадаад худалдааны дайнтай холбоотой хөрөнгийн зах зээлд тодорхойгүй байдал үүсэж байна.

Орос - Украйны дайн сунжрах магадлалтай байна. Дайнаас хамаарч түүхий эд, таваарын ханш хэлбэлзэж байна.

ДОТООД ОРЧИН

2024 оны экспортын орлого 15.8 тэрбум ам долларт хүрч өссөн байна. Мөн ОУВС, ЕСБХБ зэрэг ОУ-ын байгууллагууд МУ-ын эдийн засгийн 6%-иар төсөөлж байна.


ББСБ-ын салбарын хэмжээнд актив, нийт зээлийн багц нэмэгдэж байгаагийн зэрэгцээ чанаргүй зээлийн төвшин буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Инфляц 2024 оны эцсээр 8.4%-д хүрч Монгол банкны зорилтот интервалаас хэтэрсэн байна.

ГВАН 5.5 тэрбум ам. доллар буюу 4.8 сарын импортын хэрэгцээ хангах хэмжээнд буюу хангалтгүй төвшинд байна.

СЗХ-ны харьцаа, үзүүлэлтүүдийн өөрчлөлт нь ББСБ-ын секторын оролцогч нарыг чанаржуулах, харилцагчдыг өрийн дарамтанд орох асуудлаас урьдчилан сэргийлэхийн сацуу гадаадын хөрөнгө оруулалтыг илүүтэйгээр татах шаардлагыг бүрдүүлээд байна.

Эдийн засгийн өсөлт




5.0% - ийн өсөлт

2024 онд Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 80 их наяд төгрөгт хүрч эдийн засгийн өсөлт 5%-д хүрлээ. 2020 оноос хойш 3 жил дараалж тогтмол өсөлт үзүүлсэн эдийн засгийн өсөлт саарлаа.

6.0% - ийн өсөлт


ОУВС Монгол улсын 2025 оны эдийн засгийн өсөлтийг 6.0%-д хүрнэ гэж төсөөлсөн байна. Гэсэн хэдий ч саяхнаас цоо шинэ шатанд орж буй ОУ-ын худалдааны дайнаас шалтгаалаад энэхүү өсөлтийн төсөөллийг бууруулах өндөр магадлалтай.

Гадаад худалдаа



4.2 тэрбум \$-ын ашиг


Монгол улсын экспортын орлого 2024 онд түүхэн дээд хэмжээнд буюу 15.8 тэрбум ам.долларт хүрч 4.2 тэрбум долларын худалдааны ашигтай гарлаа. Гол бүтээгдэхүүн нүүрсний ханш бага зэрэг бууралттай байсан хэдий ч тоо хэмжээний хувьд өсөлттэй байлаа.



55% - Нүүрсний экспорт


Экспортын орлогын 55%-ийг зөвхөн нүүрсний экспорт үзүүлж 2024 оны эдийн засгийн өсөлтийн ихэнх хувийг тайлбарлаж байна. Цаашид ч эдийн засгийн өсөлт нүүрсний ханш тоо хэмжээнээс өндөр хамаарахаар байна.

Төсөв - Инфляц



33.5 их наяд - Төсөв

2025 оны улсын төсөв түүхэн хамгийн өндөр дүнгээр буюу 33.5 их наяд ₮-ийн дүнгээр батлагдаж нийтдээ ДНБ-ий 35.2%-д хүрээд байна. Нүүрсний ханшийг өндрөөр төсөөлж баталсан энэхүү төсөв инфляцад дарамт болохоор байна.




9.6% - Инфляц

Монгол улсын 2025/2-р сарын инфляц 9.6%-д хүрч Монгол банкны зорилтот 6%/+-2%/ -төвшнөөс даваад байна. Үүний хүрээнд Монгол банк бодлогын хүүг 2%-иар нэмэгдүүлж 12%-д хүргэснээр бусад хүүгийн төвшин мөн өсөв.

Салбарын мэдээлэл - ББСБ


ББСБ-ын нийт актив /2020-2024/



7.1% их наяд - Нийт актив

ББСБ-ын салбарын нийт актив жилд дунджаар CAGR-32.6%-иар өсч 2024 оны эцсийн байдлаар 7.1 их наяд төгрөгт хүрээд байна. Нийт активын өсөлт өмнөх жилүүдтэй харьцуулахад 2024 онд хурдацтай өсөлт үзүүлж 52.5%-иар өссөн байна.


ББСБ-ын зээлийн багц /2020-2024/



6.2% - Чанаргүй зээл


ББСБ-ын нийт зээлийн багц 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт активын 80% буюу 5.7 их наяд ₮-т хүрсэн байна. Чанаргүй зээлийн төвшин сүүлийн 5 жилийн хамгийн бага төвшинд буюу 6.2%-д хүрсэн сайн үзүүлэлттэй байна.

Стратеги




Эрхэм зорилго | Mission

- Дижитал шилжилтээр манлайлна.




Үнэт зүйл | Value

- Эрч хүчтэй байж бусдыг энергижүүлнэ
- Ил тод байж, итгэл даана
- Гал эрмэлзэлтэй байна
- Хурдтай гүйцэтгэл
- Хөгжилтэй байх



Алсын хараа | Vision

- Санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээг нэгтгэсэн харилцагч төвтэй хиймэл оюун ухаанд суурилсан экосистем бүтээх.



Бидний соёл | Culture

- Эерэг хандлага
- Эрсдэлд суурилсан сэтгэлгээ
- Мэргэжлийн баг
- Залуу манлайлал
- Тасралтгүй суралцах
- Амжилтад тэмүүлэгч



Хүний нөөцийн гүйцэтгэл

Хүний нөөцийн бодлого

Бид алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, ёс зүйн дүрмийн хүрээнд хүний нөөцийн бодлого тодорхойлж компанийн хүн хүчний төлөвлөлт, хүний нөөц бүрдүүлэх, сонгон шалгаруулах, тогтоон барих, дасан зохицуулах, сургаж хөгжүүлэх, залгамж болон түлхүүр ажилтан бэлтгэх, байгууллагын бүтэц зохион байгуулалтыг тодорхойлон ажилладаг.

Бид ажилтныг бүрдүүлэх, сонгон шалгаруулах функц дээрээ хүний нөөцийн нээлттэй бодлого баримтлан ажиллаж байна.

Компанийн зорилго ажилтан таны зорилготой нийцэж байхаар мэдлэг, ур чадвартай ажил горилогчийг “Зөв хүнийг, зөв албан тушаалд, зөв цагт” нь сонгон шалгаруулж авахыг зорин ажиллаж байна.

2023 оны эцсийн байдлаар Нэткапитал финанс корпораци ББСБ ХХК нь 489 идэвхтэй ажилтантай байсан бол 2024 оны 12 сарын байдлаар 595 идэвхтэй ажилтантай болж, 106 ажлын байрыг шинээр бий болголоо.



Нийт идэвхтэй
ажилтны тоо:

595



Салбарын
ажилтны тоо:

465



Нийт
салбар:

39



Төв оффисын
ажилтны тоо:

130



Дээд шатны
удирдлага:

11

Компанийн соёлын арга хэмжээ ба тогтмол зохион байгуулагддаг идэвхжүүлэлтийн ажлууд



Шинэ ажилтны сургалт

- Улирал бүр



Net Cup

- Спортын арга хэмжээ
- I-р улирал



Net Family

- Хүүхдийн баярын арга хэмжээ
- 05/31



Bus Tour

- Ажилчдын орон нутгийн аялал



Net Naadam

- Баяр наадмын арга хэмжээ
- Үндэсний хувцсаараа гоёх



NetVibe

- Идэвхжүүлэлтийн арга хэмжээх
- Улирал бүр



NetX

- Ажилчдын илтгэх ур чадварыг хөгжүүлэх
- Employer Brand-г таниулах
- Жил бүр

Бидний нэг болсноор

- 1. Эерэг дулаан уур амьсгалтай, тохилог таатай орчинд ажиллах
- 2. Удирдлага-ажилтнуудын найрсаг жигд харилцаатай соёлд нэгдэх
- 3. Залуу эрч хүчтэй, найрсаг хамт олны нэг болж тасралтгүй суралцах
- 4. Олон улсад нэвтэрсэн сайн ажлын арга барилаас эзэмших
- 5. Өсөн дэвших нээлттэй бодлого, тэгш боломжоор хангагдах
- 6. Чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх сонирхлын клубүүдэд хамрагдах


Ажилд сонгон шалгаруулах зарчим

Бид ажилтныг бүрдүүлэх, сонгон шалгаруулах функц дээрээ хүний нөөцийн нээлттэй бодлого баримтлан ажилладаг

Байгууллагын зорилго ажилтан таны зорилготой нийцэж байхаар мэдлэг, ур чадвартай ажил горилогчийг “Зөв хүнийг, зөв албан тушаалд, зөв цагт” сонгон шалгаруулж авахыг зорин ажиллаж байна.

Сонгон шалгаруулалт хийгдэх үе шат: Анкет хүлээн авах-> Анкет сонгон шалгаруулалт -> Ярилцлага уулзалт -> Ажилд авах санал -> Нэткапиталжуулах сургалт

Хүний нөөцийн сонгон шалгаруулалт





Олимп, Паралимп, Евро 2024

Гал эрмэлзэл, ур чадварт хөрөнгө оруул” гэсэн уриатайгаар “Euro-2024” Европын хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн, “Парис-2024” зуны Олимпын 33-р их наадам болон Паралимпийн 17-р наадмын шууд дамжуулалтын ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллаж, Монголын баг тамирчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэв.




Тэлэлт

Хот: 2 салбар,
Орон нутаг: 1 салбар нээсэн.



Олон Улсын эх үүсвэр

Сингапур улсын хөрөнгө оруулалтын компаниас 9 сая ам.доллар



IDCXS

Олон улсын дижитал хэрэглэгчийн туршлагын стандарт нэвтрүүлсэн.

Дижитал шилжилт

Харилцагчийн идэвх, сэтгэл ханамжийг дээшлүүлэх стратегийн хүрээнд Парисын зуны олимп болон Евро 2024 тэмцээнийг ивээн тэтгэхтэй холбоотойгоор NetPay апп-д лоялти, энтертайнмент боломжуудыг хөгжүүлэн амжилттай нэвтрүүлэв.

Лоялти - НэтПойнт

- Оноо цуглуулах
- Найзаа урих
- Эрх тогтоох
- Зээлээ хугацаандаа төлөх
- Оноо зарцуулах
- Сугалаа, купон худалдан авах
- Харилцагчийн түвшин ахих
- Шимтгэл хураамж төлөх

Энтертайнмент

- NetPay -тэй АСАР
- Евро 2024 тааврын уралдаан
- Жетур авто машины сугалаа
- Азийн хүрд

Дижитал шилжилт

Хиймэл Оюун ухаан (AI) -д суурилсан шийдлүүдээ улам сайжруулан хөгжүүлж, хэрэглэгчийн туршлага ба үнэ цэнийг нэмэгдүүлэх замаар шийдвэр гаргалтыг сайжруулж, байгууллагын дижитал шилжилтийг хурдасган, стратегийн зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлж байна.

Шинэ моделиуд

- Харилцагчийн насан туршийн үнэ цэн тодорхойлох | CLV
- Хугацаа хэтрэлт урьдчилан таамаглах | Collection Score
- Сегментчилэл
- Уламжлалт зээлийн харилцагчийн скоринг

Сайжруулсан моделиуд

- Дижитал зээлийн харилцагчийн скоринг
- Барьцаа хөрөнгийн үнэлгээ
- Автомашин
- Орон сууц



Дижитал шилжилт

Google Workspace нэвтрүүлэв

- Чат
- Баримт бичиг
- Онлайн уулзалт

Газар нэгжийн дотоод харилцаа, хамтын ажиллагааны олон салангид платформуудыг цэгцлэх зорилгоор Telegram чат, Microsoft Office, Zoom зэрэг тусдаа системүүдийг үе шаттайгаар зогсоож, Google Workspace-г байгууллагын нэгтгэсэн цогц орчин болгон амжилттай нэвтрүүллээ.

Жира тусламжийн төв

- Үйлчилгээний хүсэлт
- Зөвшөөрөл
- Ажилд орох, ажлаас гарах процессыг автоматжуулав

Мөн **Jira Helpdesk** системийг нэвтрүүлж, газар нэгжүүдийн үйлчилгээний хүсэлтүүдийг төвлөрүүлэн бүртгэдэг болсноор ажиллагаа илүү хурдан, ил тод болсон.

Үйлчилгээний чанар

- System uptime: **99.97%**
- Асуудал шийдэх дундаж хугацаа: **27 минут**

Байгууллагын бизнесийн тасралтгүй байдлыг хангахын зэрэгцээ, мэдээллийн технологийн дэмжлэг, үйлчилгээг тогтвортой, чанартай хүргэх ажиллаа.

Дотоод хяналтын тогтолцоо

Төлөөлөн удирдах зөвлөл

Гүйцэтгэх захирал

Хамгаалалтын 1-р бүс

Хамгаалалтын 2-р бүс

Хамгаалалтын 3-р бүс

Салбар

- Салбарын удирдлагын газар
- Харилцагчийн эксперинсийн газар
- Маркетинг Пи Ар газар
- Зээлийн газар
- Хөрөнгө оруулалт, удирдлагын газар
- Санхүү төлөвлөлт, удирдлагын газар
- Санхүү бүртгэлийн газар
- Стратеги менежментийн газар
- Зээлийн бүтээгдэхүүн процесс хөгжүүлэлтийн газар
- Хүний нөөц, удирдлагын газар
- Тусгай активын газар
- Дижитал шилжилт инновацын газар
- ДевОпс газар
- Программ хөгжүүлэлтийн газар

- Эрсдэлийн удирдлагын газар хуульч
- Зээлийн газар
- Санхүү төлөвлөлт, удирдлагын газар
- Санхүү бүртгэлийн газар
- Хүний нөөц, удирдлагын газар
- Дев/Опс газар

Дотоод аудитын газар

Журам дагаж мөрдөх, эрсдэлийг илрүүлэх, мэдээлэх, зайлсхийх, эрсдэлийг удирдах, дотоод хяналт хэрэгжүүлэх.

Эрсдэлийн хязгаар тогтоох хяналт хэрэгжүүлэх, заавар зөвлөмж аргачлалаар хангах, Эрсдэлийн удирдлагын газар тогтолцоог бүрдүүлэх

Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хараат бусаар хяналт тавих, бусад аудит хийх

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Эрсдэлийн удирдлага

Групп нь байгууллагын үнэ цэнийг хамгаалах, тогтвортой өсөлтийг хангах зорилгоор эрсдэлийн удирдлагын багийг байгуулан, үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй эрсдэлийн төрөл, шинж чанарыг тодорхойлж, үнэлэн, хянаж, удирдах тогтолцоог хэрэгжүүлж байна. Эрсдэлийг үр дүнтэй удирдсанаар инновацыг дэмжих, байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах, бизнесийн тогтвортой байдлыг хангах боломжийг бүрдүүлж байна.

Эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагаа

Гүйцэтгэх захирлын эрх үүрэгт хамаарах эрсдэлийн удирдлагын хороо нь батлагдсан дүрэмд заасан бүрэлдэхүүн, давтамж, хэлэлцэх асуудлын дагуу 14 хоног тутам хуралдаж, эрсдэлийг хэлэлцэн, шийдвэрлэх арга хэмжээ авч ажилладаг. 2024 онд нийт 17 удаа хуралдсан бөгөөд үүсэж буй эрсдэлийг шийдвэрлэх, хяналтын тайланг хэлэлцэх, эрсдэлийн хязгаар лимитийн хэрэгжилтийг хянах, МУТСТ хууль, журам болон Зохицуулагч байгууллагын шалгуур, шаардлагыг хангуулах гэх мэт дүрэмд заасан хэлэлцэх шаардлагатай асуудлуудыг бүрэн хамруулж, шийдвэрийн хэрэгжилтийг Эрсдэлийн удирдлагын газраас хянаж байна.

Эрсдэлийн удирдлагын засаглал, тогтолцоо

Групп нь эрсдэлийн удирдлагын засаглалаа 2023 онд Гүйцэтгэх захирлын эрх үүрэгт хамаарах хороодоор дамжуулан хэрэгжүүлсэн бол 2024 оноос ТУЗ-ийн дэргэд “Эрсдэлийн удирдлагын хороо”-г шинээр байгуулан ажиллаж байна. Группийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь хамгаалалтын гурван бүсийн зарчим баримтлах ба эрсдэлийг хариуцах, хянах удирдах, засаглалыг бүрдүүлэх чиг үүргүүдийг хуваарилан ажилладаг.

Эрсдэлийн удирдах баримт бичгүүд

Группийн нийт эрсдэлийг дараах 8 ерөнхий төрөлд ангилж байна. Үүнд:

- Стратегийн эрсдэл, Санхүүгийн эрсдэл, Зээлийн эрсдэл, Үйл ажиллагааны эрсдэл, Нийцлийн эрсдэл, Нэр хүндийн эрсдэл, Мэдээллийн технологи, аюулгүй байдлын эрсдэл , Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн удирдлага

Дээрх эрсдэлийн төрөл тус бүрд нь эрсдэлийг удирдах журам болон арга аргачлалуудыг боловсруулан мөрдөж байна.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

1. Стратегийн эрсдэлийн удирдлага

Группийн стратегийн төлөвлөгөөнд нөлөөлөх гадаад болон дотоод орчны эрсдэл, боломжуудыг Гүйцэтгэх удирдлагын баг жил бүр үнэлэн шинэчилж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг. Эдгээр арга хэмжээний хэрэгжилт болон үр нөлөөг OKR аргачлалд үндэслэн тогтмол хянаж, стратегийн зорилтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Групп нь санхүүгийн эрсдэлийг хяналттай удирдах зорилгоор Зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд болох өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, активын төвлөрөл, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ болон үндсэн хөрөнгийн харьцааг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд байлгаж, тогтвортой байдлаа хадгалан ажиллаж байна.

3. Зээлийн эрсдэлийн удирдлага

Групп нь “Зээлийн эрсдэлийг удирдах журам”-ын хүрээнд зээлдэгч, зээлийн бүтээгдэхүүн, барьцаа хөрөнгийн эрсдэлийн хязгааруудыг тодорхойлон, зээлийн багцыг оновчтой бүрдүүлэх зарчимд тулгуурлан ажиллаж байна.

Мөн зээлийн эрсдэлийн дохиог эрт илрүүлэх системийг хэрэгжүүлж, зээлдэгчийг таних скорингийн загварт тасралтгүй сайжруулалт хийж, барьцаа хөрөнгийн үнэлгээний процессыг автоматжуулах замаар хүнээс хамаарах эрсдэлийг бууруулах бодлого баримталж байна.

4. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Групп нь үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор ISO 9001:2015 стандартад нийцүүлэн SIPOC зураглалын аргачлалаар байгууллагын нийт процессын хүрээнд эрсдэлийг тодорхойлж, үнэлгээ хийдэг. Үүний үндсэн дээр боловсруулах хариу арга хэмжээг төлөвлөж, түүний хэрэгжилтийг улирал бүр хянан, тасралтгүй сайжруулалт хийж байна.

5. Нийцлийн эрсдэлийн удирдлага

Групп нь Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай (МУТСТ) хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журмуудын дагуу нийцлийн эрсдэлийг удирдах журмыг боловсруулан баталж, тогтолцоог бүрдүүлэн хэрэгжүүлж байна.

Энэхүү тогтолцооны хүрээнд эцсийн өмчлөгчийг тодорхойлох, санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хориг жагсаалтад багтсан этгээдийг илрүүлэх зэрэг өндөр эрсдэл бүхий харилцагчийг тодорхойлох автоматжуулсан системийг нэвтрүүлж, хууль, зохицуулалтад нийцээгүй харилцаа, гүйлгээ үүсэхээс сэргийлж байна.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

6. Нэр хүндийн эрсдэлийн удирдлага

Групп нь нэр хүндийн эрсдэлийг “эрсдэлийн аппетит”-даа тусган, цахим орчны сөрөг мэдээллийн тоо, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ (CSAT), санал болгох индекс (NPS), хэрэглэгчийн хүчин чармайлтын индекс (CES), асуудал шийдвэрлэсэн түвшин (CCR), анхны холбоогоор шийдвэрлэсэн хувь (FCR) зэрэг голлох үзүүлэлтүүдээр сар бүр хэмжилт хийж, дүн шинжилгээг Эрсдэлийн хороонд тогтмол тайлагнаж байна.

7. Мэдээллийн технологи, аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага

Салбарын өрсөлдөөн технологийн хурд, мэдээлэл боловсруулах болон солилцох чадвараар тодорхойлогдож буй өнөөгийн нөхцөлд мэдээллийн технологи болон аюулгүй байдлын эрсдэл шууд хамааралтайгаар өсөн нэмэгдэж байна.

Иймд байгууллагын үнэ цэнтэй мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хангах зорилгоор Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог (МАБМТ) дараах хяналтын арга хэмжээг ашиглан хэрэгжүүлж байна:

Хортой кодын эсрэг хамгаалалт, Физик нэвтрэлтийн хяналт, Системийн эмзэг байдлын хяналт, Эрхийн зохицуулалт Логийн удирдлага, Дижитал шинжилгээ (digital forensics).

Групп нь ISO/IEC 27001:2013 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд хоёр дахь жилдээ амжилттай магадлан аудит хийлгээд байна.

8. Байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага

1. Групп нь байгаль орчин болон олон нийтэд сөрөг нөлөө үзүүлэх аливаа үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд хориглох чиг үүрэг бүхий салбар, үйл ажиллагааг “Эрсдэлийн удирдлагын бодлого”-д тодорхойлон тусгасан байдаг.

2. Нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийтэд чиглэсэн төсөл, арга хэмжээнд зориулсан тусгай санхүүжилт батлан, хэрэгжүүлдэг.

3. Хөдөлмөр, эрүүл мэнд, аюулгүй байдлын чиглэлээр нийт ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажлын байрны аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлийг бүрдүүлж, эрсдэлийг урьдчилан сэргийлэх арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж байна.

Дотоод аудитын тогтолцоо

Дотоод аудитын зорилго

Дотоод аудитын газар нь “Нэткапитал Финанс корпораци ББСБ” ХХК-ийн Компанийн засаглал, стратеги, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын процессын үр дүнтэй байдалд эрсдэлд суурилсан, мэргэжлийн, хараат бус аудитыг гүйцэтгэн үнэлж, тэдгээрийг тогтмол сайжруулах зөвлөмж болон баталгаажуулалтаар хангана.

Дотоод аудитын тогтолцоо

1. Дотоод аудитын газар нь хараат бус байх ба ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд харьяалагдаж, тайлагнаж, мөн дараахыг шийдвэрлүүлнэ. Үүнд:

- Дотоод аудитын дүрэм журмыг батлуулах
- Эрсдэлд суурилсан дотоод аудитын жилийн төлөвлөгөөг батлуулах
- Дотоод аудитын газрын төсөв болон нөөцийн төлөвлөгөөг батлуулах
- Менежментийн талаас дотоод аудитын газрын үйл ажиллагааны хамрах хүрээ

2. ДАГ нь нэгж аудитыг сонгох, аудитын хамрах хүрээ, зорилго, шалгуур үзүүлэлт, аудитын давтамж, тайлангийн агуулгыг тодорхойлохдоо компанийн бусад газар, нэгжийн нөлөөллөөс ангид байна. Ингэснээр хараат бус, бодит байдлыг бий болгоно. Хараат бус, бодит байдал алдагдсан эсвэл алдагдах нөхцөл үүссэн тохиолдолд Аудитын хороонд мэдэгдэнэ.

Дотоод аудитын бүтэц ба зохион байгуулалт

1. ДАГ нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд шууд харьяалагдаж тайлагнана.
2. ДАГ нь газрын захирал, ахлах аудитор, аудитор гэсэн бүтэцтэй байна.
3. ДАГ нь Олон улсын дотоод аудитын стандарт ба ёс зүйн дүрэм, Дотоод аудитын газрын бодлого, дүрэм, журамд нийцэж ажиллана.



ДИЖИТАЛ ШИЛЖИЛТЭЭР МАНЛАЙЛНА